



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Чандманьналайх” ААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2026/187/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Газрын дарга, тэргүүлэх аудитор: Г.Нандинжаргал Утас: 70007734 Цахим хаяг: nandinjargalg@audit.gov.mn Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Я.Алтанцэцэг Утас: 315558 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК Захирал А.Сарангэрэл Утас: 99884842 Цахим хаяг: Gereltekhburtgelaudit8@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.03.13 № 671
танай _____-ны № _____-т

ЧАНДМАНЬ НАЛАЙХ ААТҮГ-ЫН
ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.БАТБИЛЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Чандманьналайх ААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

“Чандманьналайх” ААТҮГ нь тайлант онд 3,770.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 5,764.4 сая төгрөгийн зардал гаргаж, 1,193.7 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Аудитын гол асуудал

Тус газар нь Налайх дүүргийн 252 аж ахуйн нэгж байгууллага, гэр хорооллын 10000 гаруй айл өрх, орон сууцны 3704 айл өрхөд нийт 507643 тонн цэвэр ус түгээж бохир усыг татан зайлуулж, гэр хорооллын айл өрхөд 62196 тонн ус хүргэж, цэвэр, бохир ус ариутгах татуургатай холбоотой 24 цагийн диспетчерийн үйлчилгээг үзүүлж, нийт 5340 дуудлага хүлээн авч шийдвэрлэж ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 24 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллахаар төлөвлөснөөс 94.3 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

1426950657

C:\Users\marangua\Desktop\Бичиг газар 2026\2026\word\улаан бичиг\Дүгнэлт_2026.docx

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

1.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		1 сарын 1	12 сарын 31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	176,607,816.06	62,646,496.78
1.1.02	Дансны авлага	495,802,591.40	418,674,331.01
1.1.04	Бусад авлага	147,688,604.03	87,999,512.37
1.1.06	Бараа материал	347,041,090.60	145,129,631.70
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	30,618,875.30	77,325,728.03
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,197,758,977.39	791,775,699.89
1.2.01	Үндсэн хөрөнгө	11,137,152,336.04	10,319,408,435.55
1.2.02	Биет бус хөрөнгө	4,092,574,143.64	4,092,574,143.64
1.2.09	Дуусаагүй барилга	8,164,727.27	-
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	15,237,891,206.95	14,411,982,579.19
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	16,435,650,184.34	15,203,758,279.08
2.1.1.01	Дансны өглөг	3,574,427,468.51	4,010,920,617.11
2.1.1.03	Татварын өр	510,546,498.97	714,649,132.00
2.1.1.04	НДШ - ийн өглөг	48,274,212.66	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	1,003,982,125.99	-
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	5,137,230,306.13	4,725,569,749.11
2.1.2.05	Хойшлогдсон орлого	-	989,387,464.54
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	989,387,464.54
2.2	Өр төлбөрийн нийт дүн	5,137,230,306.13	5,714,957,213.65
2.3.01	Өмч: - төрийн	9,620,734,767.62	9,620,734,767.62
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	10,036,090,982.90	10,036,090,982.90
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	4,465,081,762.18	4,465,081,762.18
2.3.09	Хуримтлагдсан ашиг	-12,823,487,634.49	-14,633,106,447.27
2.3.09.1	Тайлант үеийн ашиг	-	-1,809,618,812.78
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	-12,823,487,634.49	-12,823,487,634.49
2.3.11	Эздийн өмчийн дүн	11,298,419,878.21	9,488,801,065.43
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	16,435,650,184.34	15,203,758,279.08

1.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
01	Борлуулалтын орлого (цэвэр)	3,500,884,944.51	3,631,612,067.39
02	Борлуулалтын өртөг	5,015,445,397.75	5,352,419,678.44
03	Нийт ашиг(алдагдал)	-1,514,560,453.24	-1,720,807,611.05
08	Бусад орлого	190,549,007.64	323,206,848.94
08.1	Орлогын дүн	190,549,007.64	323,206,848.94
10	Ерөнхий ба удирдлагын зардал	316,277,652.37	410,290,801.35
12	Бусад зардал	10,499,436.00	1,727,249.32
12.1	Зардлын дүн	326,777,088.37	412,018,050.67
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	-1,650,788,533.97	-1,809,618,812.78
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-1,650,788,533.97	-1,809,618,812.78
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-1,650,788,533.97	-1,809,618,812.78

1.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөр-н дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	9,620,734,767.62	10,036,090,982.90	4,064,137,780.00	-11,015,748,100.52	12,705,215,430.00
04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-1,807,739,533.97	-1,807,739,533.97
06	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	400,943,982.18	-	400,943,982.18
09	2024 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	9,620,734,767.62	10,036,090,982.90	4,465,081,762.18	-12,823,487,634.49	11,298,419,878.21
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-1,809,618,812.78	-1,809,618,812.78
17	2025 оны 12 сарын 31-р үлдэгдэл	9,620,734,767.62	10,036,090,982.90	4,465,081,762.18	-14,633,106,447.27	9,488,801,065.43

1.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	4,053,903,401.34	4,242,511,736.37
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	3,014,324,637.28	3,081,609,969.40
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	5,300,955.00	1,670,710.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	1,000,000,000.00	1,100,000,000.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	34,277,809.06	59,231,056.97
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	3,909,414,119.41	4,282,243,555.65
1.2.1	Ажиллагчдад төлсөн	1,599,054,464.47	1,585,129,981.63
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	426,390,768.06	518,000,000.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	439,416,187.80	942,755,018.30
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	350,780,656.05	428,819,816.94
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	568,549,779.00	106,114,000.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	170,150,548.77	333,551,841.58
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	820,935.00	1,812,232.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	354,250,780.26	366,060,665.20
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	144,489,281.93	-39,731,819.28
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	74,229,500.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	74,229,500.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-74,229,500.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	144,489,281.93	-113,961,319.28
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	32,118,534.13	176,607,816.06
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	176,607,816.06	62,646,496.78

1.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2024 оны гүйцэтгэл	2025.12.31		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	2	3	4	5	6	7
A	Орлого төвлөрүүлэлт					
1	ОСА-1	1,696,971,392.8 ₄	2,300,000,000.00	1,988,612,477.39	-311,387,522.61	86.5
2	ОСА-2	327,296,220.00	340,000,000.00	331,671,880.00	-8,328,120.00	97.6
3	ЗУХХ	225,106,060.95	360,000,000.00	211,327,710.00	-148,672,290.00	58.7
Б					-	
4	Бусад орлого	532,969,369.26	26,000,000.00	323,206,848.94	297,206,848.94	1243.1
5	Нэмэлт санхүүжилт	909,090,909.10	1,000,000,000.00	1,100,000,000.00	100,000,000.00	110.0
Нийт дүн		3,691,433,952.1₅	4,026,000,000.00	3,954,818,916.33	-71,181,083.67	98.2
1	Цалин хөлс	1,865,732,499.7 ₃	2,238,878,000.00	1,944,689,141.15	294,188,858.85	86.9
2	Нийгмийн даатгалын шимтгэл	255,054,630.47	306,066,000.00	247,505,975.04	58,560,024.96	80.9
3	Хоол унааны нэмэгдэл	156,951,000.00	187,200,000.00		187,200,000.00	0.0
4	Худалдаж авсан усны зардал	527,919,924.63	570,101,000.00	519,779,945.00	50,321,055.00	91.2
5	Бичиг хэргийн зардал	6,714,737.25	7,048,000.00	11,863,279.78	-4,815,279.78	168.3
6	Цахилгааны зардал	270,962,600.96	379,348,000.00	348,878,883.92	30,469,116.08	92.0
7	Дулааны зардал	19,926,192.10	35,866,000.00	19,123,985.62	16,742,014.38	53.3
8	Сантехникийн материалын зардал	133,317,714.88	136,900,000.00	122,176,599.99	14,723,400.01	89.2
9	Сэлбэг хэрэгслийн зардал	52,587,876.45	84,214,000.00	37,048,272.68	47,165,727.32	44.0
10	Барилгын материалын зардал	9,816,736.03	11,776,000.00	16,713,258.20	-4,937,258.20	141.9
11	Нүүрсний зардал	609,979,534.43	1,000,000,000.00	395,523,087.43	604,476,912.57	39.6
12	Хангамжийн материалын зардал	12,648,090.54	14,977,000.00	16,631,374.47	-1,654,374.47	111.0
13	Засвар үйлчилгээний зардал	26,000,058.28	105,242,000.00	306,342,350.40	-201,100,350.40	291.1
14	Түрээсийн зардал /байр, тоног төхөөрөмж/	36,000,000.00	-	-	-	
15	Шатахууны зардал	105,582,324.73	126,098,000.00	97,399,627.90	28,698,372.10	77.2
16	Татвар даатгалын зардал	574,923.00	7,250,000.00	6,513,668.00	736,332.00	89.8
17	Утас, интернэтийн зардал	13,193,150.23	14,507,000.00	10,494,497.58	4,012,502.42	72.3
18	Элэгдлийн зардал	1,137,685,685.5 ₃	1,137,685,000.00	1,084,905,264.12	52,779,735.88	95.4
19	Шагнал	2,660,000.00	5,000,000.00	2,600,000.00	2,400,000.00	52.0
20	Хөдөлмөр хамгааллын зардал	17,464,258.33	70,655,000.00	32,671,258.59	37,983,741.41	46.2
21	Тэтгэмж зардал	-	100,000,000.00	55,232,000.00	44,768,000.00	55.2
22	Нийгмийн зардал	56,290,574.40	45,170,000.00	19,751,000.00	25,419,000.00	43.7
23	Бохир ус татан зайлуулах	8,505,665.00	9,245,000.00	0	9,245,000.00	0.0
24	Банкны үйлчилгээний зардал	5,447,171.66	5,447,000.00	2,203,752.38	3,243,247.62	40.5
25	Лаборторын зардал	970,516.13	4,000,000.00	4,007,272.75	-7,272.75	100.2
26	Програмын зардал	4,020,781.82	9,600,000.00	14,601,500.02	-5,001,500.02	152.1
27	Гадны үйлчилгээний хөлс	9,500,000.00	20,000,000.00	9,500,000.00	10,500,000.00	47.5
28	Сургалтын зардал	1,860,000.00	15,550,000.00	7,030,000.00	8,520,000.00	45.2

“Чандманьналайх” ААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

29	Зохицуулалт үйлчилгээний хөлс	-	25,481,000.00	14,165,390.00	11,315,610.00	55.6
30	Бусад зардал	141,307,403.54	50,000,000.00	415,359,094.76	-365,359,094.76	830.7
32	Үйл ажиллагааны бус бусад зардал	10,499,436.00	-	1,727,249.32	-1,727,249.32	
	Нийт дүн	5,499,173,486.12	6,723,304,000.00	5,764,437,729.10	958,866,270.90	85.7
1	Татварын өмнөх ашиг/алдагдал	- 1,807,739,533.97	- 2,697,304,000.00	-1,809,618,812.77		67.1
3	Цэвэр ашиг/алдагдал	- 1,807,739,533.97	- 2,697,304,000.00	-1,809,618,812.77		67.1
5	Хөрөнгө оруулалт			5,764,437,729.10		
8	Нийт авлага	643,471,195.43	500,000,000.00	583,999,571.41	-83,999,571.41	116.8
9	Нийт өр төлбөр	5,137,230,306.13	4,000,000,000.00	5,884,650,537.79	- 1,884,650,537.79	142.9

2. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,739,202.4 мянган төгрөгийн 4 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул аагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн бус үйл ажиллагааны орлогыг борлуулалтын орлогоор бүртгэж, тайлагнасан.	1	30,078.4	-	-	1	30,078.4	1	30,078.4	-	-	-	-
Худалдаж авсан усны өртгийн үндсэн дансны нэршлийг буруу ангилж, тайлагнасан.	1	519,779.9	-	-	1	519,779.9	1	519,779.9	-	-	-	-
Бусад богино хугацаат өр төлбөрийн хасагдуулга дансанд үнэ төлбөргүй шилжин ирсэн үндсэн хөрөнгийг бүртгэж, тайлагнасан.	1	992,984.1	-	-	1	992,984.1	1	992,984.1	-	-	-	-
Орлого үр дүнгийн тайлангийн бусад орлогыг үнэ төлбөргүй шилжин ирсэн үндсэн хөрөнгийн нийт дүнгээр тайлагнаж, ашиг алдагдлыг буруу толилуулсан.	1	196,360.0	-	-	1	196,360.0	1	196,360.0	-	-	-	-
Дүн	4	1,739,202.4	-	-	4	1,739,202.4	4	1,739,202.4	-	-	-	-

Аудитаар нийт 61,338.9 мянган төгрөгийн 5 зөрчил² илэрснээс, 1,490.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 13,850.0 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 45,998.9 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Үр ашиггүй зардал гаргасан.	1	1,490.0	1	1,490.0	-	-	-	-	-	-	-	-
Он дамжсан авлагыг барагдуулаагүй, үлдэгдлийг баталгаажуулаагүй.	1	11,000.00	-	-	1	11,000.0	-	-	-	-	-	-

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Он дамжсан өглөгийг үлдэгдлийг баталгаажуулаагүй, шийдвэрлээгүй.	1	2,850.0			1	2,850.0	-	-	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өмчлөлийг бүртгүүлээгүй.	1	-					1	-				
Худалдан авалт ибаримтаар баталгаажаагүй.	1	45,998.9					1	45,998.9				
Дүн	5	61,338.9	1	1,490.0	2	13,850.0	2	45,998.9	-	-	-	-

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн аудитаар илэрсэн нийт 3,299,663.1 мянган төгрөгийн 3 зөрчлөөс 3,299,663.1 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1 зөрчилд зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төрийн хэмнэлтийн хуультай холбоотой зөрчил								
Захиалгын хүсэлт илгээж, цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй	1	9,806.1	-	-	1	9,806.1	-	-
Дүн	1	9,806.1	-	-	1	9,806.1	-	-
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.	1	3,289,856.8	-	-	1	3,289,856.8	-	-
Дүн	1	3,289,856.8	-	-	1	3,289,856.8	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Ахмадын сан байгуулаагүй	1	-		-	-	-	1	-
Дүн	1	-	-	-	-	-	1	-
Нийт дүн	3	3,299,663.1	-	-	2	3,299,663.1	1	-